

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

ГАЗРЫН “ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 11



Улаанбаатар хот

Газрын албан хаагчид дараах олон нийт үйл ажиллагаа, спортын тэмцээн уралдаан зохион байгуулж оролцов. Үүнд:

Нэг. Олон нийтийн арга хэмжээ:

Нийслэлийн харьяа байгууллагуудаас зохион байгуулагдсан 2 удаагийн олон нийтийн арга хэмжээнд давхардсан тоогоор 88 албан хаагч оролцов.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжийн дагуу “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан, газрын даргаар батлуулав. 2024 оны 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд 09:00-15:00 цагийн хооронд Сүхбаатарын талбайн урд талын усан оргилуурыг угааж цэвэрлэн, цэцэрлэгт хүрээлэнгийн сандал, хайс, хашлага, явган хүний замыг цэвэрлэн мод, бут, зүлгийн ил задгай хог хаягдлыг 73 албан хаагч цэвэрлэв.



2.Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар батлагдсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай газар Чингэлтэй дүүргийн 19-р хороо Дэд салхитын аманд 3 га газарт үечлэн 5000 мод тарих ойжуулах, тохижилтийн ажил хийхээр төлөвлөн зураг төслийг боловсруулж, Чингэлтэй дүүргийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгуулсан. Тус ажлын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 77 ажилтан, 100 ширхэг Шинэс мод, 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 26 албан хаагч, 30 ширхэг Шинэс модыг тус тус тарив.



2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр “Арчлахгүй бол ургахгүй” уриан дор Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, “Охь-Мандал” ХХК-тай мод тарих, арчлах, ургуулах хамтран ажиллах гэрээг байгуулан гэрээний дагуу тус компанийн мэргэжилтнүүдээс заавар, зөвлөгөө авч, 15 ширхэг “Шинэс” модыг 15 албан хаагч тарив. Мөн өмнө онуудад суулгасан модны цэнэг усалгаа, арчилгааг хийв.



2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр намрын мод тарих ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 19-р хороо Дэд салхитын аманд 15 ширхэг Шинэс мод тарив. Мөн өмнөх жилүүдэд тарьсан модны цэнэг нөхөх усалгааг хийв.



2024 оны байдлаар нийт 160 ширхэг Шинэс мод тарьж, ургуулж, арчилсан байна.

Хоёр. Спортын тэмцээн уралдаан

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/13 дугаар тушаалаар “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан, хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, 01 дүгээр сарын 24-ний өдөр газрын даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөг газрын “НХОГ-СОЁЛ, СПОРТ” дотоод сүлжээнд байршуулан нийт албан хаагчдад танилцуулав.

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 4 удаагийн тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 173 албан хаагч хамрагдав.

Төлөвлөгөөний хүрээнд газрын хэмжээнд 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулав.

1. Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, багаар хамтарч ажиллах чадварт сургах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, “Соёл, спорт хамтлаг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд “Гар бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр гаргаж, газрын даргаар 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр батлуулав.

Тэмцээнийг 2024 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спорт хорооны зааланд “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг зохион байгуулав. Нийт 5 багийн 75 тамирчин оролцож, М клубын 2 шүүгч шүүн явуулав.



Багуудын дунд хөгжөөнт тэмцээнийг “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсгээс санаачлан зохион байгуулав. Тэмцээнд 5 багийн 30 тамирчин оролцож, “Алт авсан байвал яах уу” баг түрүүлж мөнгөн шагналаар шагнагдав.



2.Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг удирдамж, хөтөлбөр боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр газрын даргаар батлуулан, “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг 03 дугаар сарын 16-ны өдөр Ус сувгийн удирдах газрын спорт зааланд зохион байгуулж, нийт 67албан хаагч оролцов.



Бусад цаг үеийн олон нийтийг хамарсан спортын тэмцээн уралдаанд (Цасны баяр, Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит 5 төрөлт тэмцээн, Улаанбаатар марафон-2024) тухай бүр зохион байгуулалтыг хангаж, оролцов.

1.Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр ирүүлсэн 03/22 дугаар албан бичгийн хүрээнд газрын албан хаагчдыг “Цасны баяр” өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулахаар төлөвлөгөө гарган, хөтөлбөр боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр газрын даргаар батлуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллав.

2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдах арга хэмжээ тус газраас 01 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн 02/32 дугаар албан бичгийн хүрээнд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан түр хойшлогдож, зохион байгуулагдаагүй.

2.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн 01/375 дугаар албан бичгийн хүрээнд Ерөнхий менежерийн нэрэмжит спортын 3 төрөлт (сагсан бөмбөг, дартс, шатар) тэмцээн 2024 оны 04 дүгээр сарын 23,24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, 3 төрлийн тэмцээнд 21 албан хаагч төрөл тус бүрд амжилттай оролцов.



3. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/241 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 02/116 дугаар хамтран ажиллах тухай ирүүлсэн албан бичиг, удирдамжийн дагуу зохион байгуулалтын ажлыг хангаж, албан хаагчид амжилттай оролцов.

“Улаанбаатар марафон-2024” гүйлтийн талаарх мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан, албан хаагчдад мэдээлэл хүргэв. 5 км-т 8, 10 км-т 1, 21 км-ийн зайд гүйх 1 албан хаагчийн мэдээллийг <http://ubmarathon.hipay.mn/> хаягаар онлайнаар бүртгэлжүүлэн, төлбөрийг hipay апплейкешнаар хийж баталгаажуулав. “Улаанбаатар марафон-2024” Олон улсын гүйлт 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 10 албан хаагч амжилттай оролцов.



Тэмцээн зохион байгуулсан болон оролцсон талаарх мэдээллийг тухай бүр газрын цахим хуудсаар нийтлэн ажиллав.

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 7 удаагийн тэмцээн уралдаан, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 276 албан хаагч хамрагдав.